

Завхан аймаг дахь  
Төрийн Аудитын газар

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код: ЗАА-2018/278/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [zavkhan@audit.gov.mn](mailto:zavkhan@audit.gov.mn)

Дарга, тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 7046-3612, 9905-8189

Цахим хаяг: [zavkhan@audit.gov.mn](mailto:zavkhan@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 7046-2813, 9901-9467, 9832-3586

Цахим хаяг: [khash\\_aud@yaoo.com](mailto:khash_aud@yaoo.com)

Аудитор: Г.Чулуунбаатар

Утас: 9908-4581, 8833-4581

Цахим хаяг: [chuka4581@gmail.com](mailto:chuka4581@gmail.com)

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	3
	Оршил.....	3
	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	7
	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....	7
	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	7
	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
	Шилэн дансны мэдээлэл .....	9
	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал .....	11
	«management_zurchil1».....	12
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17

## 1. Аудитын гэрчилгээ



### ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2018.02.28 № 143  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА  
Д.БАТМЭНД ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.УЛАМБАЯР

STB-2017

152 412

## **2. Аудитын тайлан**

### **Оршил**

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.02.19-нөөс 2018.02.21-ний хооронд хийж, аудитын тайланг 2018.02.23-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрыг Гүйцэтгэлийн аудитын албаны аудитор Гончигбал овогтой Чулуунбаатар хариуцаж хэрэгжүүлэв.



Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018.01.23-нд төрийн аудитын байгууллагад 2018.01.23-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж-Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь “Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах” эрхэм зорилгын дор Завхан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ.

Тайлант хугацаанд Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь: Худалдан авах ажиллагаа ил тод нээлттэй болох, Засгийн газрын 193 дугаар тогтоолын биелэлтийг хангуулах зорилт, Засгийн газрын 193 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгыг тус тус дэвшүүлэн ажиллажээ.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Худалдан авах ажиллагааг 50 хувиас доошгүй цахим хэлбэрээр зохион байгуулах

#### **Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ний "Acolous 3.0" санхүүгийн программ хангамж ашиглажээ.

Энэхүү программ нь Сангийн яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн байна.

#### **Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 0 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 0 асуудал эрсдэл өндөр, 0 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 0 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 0 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих-шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

#### **МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь УЗХ-ын шийдвэртэй холбоотой юм.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь 245.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь нь 2.45 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь санхүүгийн аудитын журмын дагуу сонгосон болно.

#### **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 0 чиглэлээр 0 эрсдэлтэй асуудалд 0 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 0 хувь буюу 0 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	4.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	4.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

#### **Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ**

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежментийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

#### **Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал**

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал**

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### **Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар сахилгын шийтгэл ногдуулах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**



Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол /"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"/-уудыг мөрдөж ажилласан эсэхэд анхаарал хандуулах

#### **Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 117,398,349 төгрөг, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсвийг батлуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	117.4	132.8	113.1%	15.4
1.1	Урсгал зардал	117.4	132.8	113.1%	15.4
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл 113.1 хувь байгаа нь төлөвлөлт буруу хийгдсэн /11 орон тоотой ажиллаж байхад 9 ажилтнаар цалингийн санхүүжилт орж ирдэг/, ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын ажиллаагүй хугацааны цалин зэрэгтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 114.0 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө биелсэн нь тендер худалдан авалтын орлого болон дуудлага худалдаагаар хөрөнгө борлуулсаны орлоготой холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 7.5 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 0, хөрөнгийн зардалд 0 төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

### **Шилэн дансны мэдээлэл**

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 0 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 0 горим сорил хэрэгжүүлэв.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017.10.24-ний өдрийн 461 тоот албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

### **Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

**АУДИТЫН ТАЙЛАНГ  
ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР 2018.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ХАШЦЭЦЭГ 2018.02.25

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР 2018.02.23

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

## **ЗАРДАЛ**

### **Илрүүлэлт**

Автомашины сэлбэг 4,729.9 мянган төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

### **Зөвлөмж**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж бараа материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх

### **Хариуцах ажилтан**

Дарга, нягтлан бодогч

### **Эрсдэл**

- Үргүй зардал гаргах
- Автомашины сэлбэгийн ашиглалтанд тавих хяналт алдагдах

### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



**Дээд түвшний хяналт:**

**Удирдлагын анхааралд**

**Илрүүлэлт**

Нярав Т.Алтантуяа нь 2017 оны 06 сараас жирэмсний амралтаа авсан бөгөөд няравын ажлыг бусад ажилтанд хариуцуулаагүй, нягтлан бодогч Г.Дашбалжир давхар хийж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.4 дэх заалтуудыг зөрчиж байна.

**Зөвлөмж**

2018.01.01-нээс няравын ажлыг нягтлан бодогчоос өөр мэргэжлийн ажилтанд хариуцуулж ажиллуулах

**Хариуцах ажилтан**

Дарга, нягтлан бодогч

**Эрсдэл**

Анхан шатны болон бүртгэлээр тавих хяналтууд алдагдах

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Зөвлөмжийн биелэлтийн хариуг 2018.06.15-ны дотор албан тоотоор ирүүлэх

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ  
ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР 2018.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ХАШЦЭЦЭГ 2018.02.25

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР 2018.02.23

**4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

---

- a. Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
- b. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**
- c. Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
- d. Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**